



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: МУИС, Бизнесийн сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Нягтлан бодох бүртгэл

Индекс: E04110101

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Энх-Амгалан

Гишүүд: С.Өлзийбат

С.Алтанцэцэг

Он сар өдөр: 2018-12-25

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС, Бизнесийн сургууль School of Business, National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нягтлан бодох бүртгэл Accounting	
Индекс	E04110101	
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. Л.Энх-Амгалан ММНБИ-ийн гүйцэтгэх захирал, доктор Ph.D, профессор Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. С.Өлзийбат Мандах их сургуулийн МТС-ийн захирал, доктор Ph.D, профессор 3. С.Алтанцэцэг ХААИС-ийн ЭЗБС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал, доктор Ph.D, дэд профессор	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Б.Оюунчимэг-Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагvv бичнэ/
	12/05	Ажлын албатай гэрээ байгуулах
	12/12	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	12/17,18	Сургууль дээр очиж ажиллана.
	12/25	Үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	12/26	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	12/29	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	1 сард	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор баталсан Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг мөрдөнө. Шинжээчийн баг нь БМИУЗ-ийн дүрмийн 8.4.5, Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2 дахь заалтуудыг үндэслэн гэрээ байгуулан ажилласан.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн Бизнесийн сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхим 1997-1998 оны хичээлийн жилээс эхлэн нягтлан бодох бүртгэлээр магистрын элсэлт авч, сургалтын шаталсан хэлбэрийг хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн бизнесийн удирдлагын 680 гаруй, үүнээс сүүлийн 10 жилд 451 магистр бэлтгэн гаргажээ. 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн судалгааны магистрын зэрэгцээ мэргэжлийн магистр бэлтгэх хэлбэр хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Нягтлан бодох бүртгэлийн тэнхим 26 багштайгаар мэргэжлийн сургалтыг өдөр, орой, эцнээ хэлбэрээр бакалавр, магистр, докторын түвшинд явуулж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байна. Өөрийн орны төдийгүй дэлхий нийтийн чиг хандлагыг судалж үнэлэлт, дүгнэлт өгчээ.
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил СЭЗИС-ийн НББ-ийн магистрын хөтөлбөр, ХААИС-ийн НББ-ийн магистрын хөтөлбөр болон Лондонгийн Эдийн засгийн сургууль, Харвардын Бизнесийн сургууль, Сингапурын Менежментийн их сургууль, Печийн их сургууль, Өмнөд Австралийн их сургууль, Амстердамын их сургууль зэрэг гадаадын хөтөлбөрүүдтэй харьцуулж үзсэн байна. Өөрийн давуу болон сул талаа бодитойгоор тодорхойлж, цаашид Өгөгдлийг удирдлагад ашиглах, НББ-ийн мэдээллийн систем, Бизнесийн ахисан түвшний тооцооллыг загварчлах зэрэг хичээлийг сургалтын төлөвлөгөөнд нэмэх шаардлагатай гэж үзсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад, дотоодын олон их сургуулийн ижил төрлийн хөтөлбөрүүдийг харьцуулан судалж хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөгөө боловсруулж байна.

Анхаарах асуудал:

- Оролцогч, сонирхогч талуудтай хөтөлбөрийн өнөөгийн байдал, ололттой болон дутагдалтай тал, ажил олгогчийн шаардлагыг хангаж байгаа байдал, ирээдүйн чиг хандлагын талаар илүү ойр хамтран ажиллах.

Зөвлөмж:

- Эдийн засаг, бизнес, технологийн шинэчлэлийг харгалзан мэргэжлийн ирээдүйн чиг хандлагыг сайтар судлан хөтөлбөрөө шинэчилж байх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Уг хөтөлбөрийн зорилго нь манай улсын мэргэшлийн хүрээнд тавигдаж буй шаардлагатай нийцсэн байна.
- Мөн МУИС-ийн болон МУИС-ийн Бизнесийн сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байна.

- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байна.
- Хөтөлбөрийн зорилгоо 2007, 2011, 2016 онд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчилж байсныг зохих баримтад тусгасан байна. Эдгээрийг тэнхимийн танилцуулга, самбар, вебсайтаар олон нийтэд мэдээлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Өөрийн орны мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад хөтөлбөрийн танилцуулгыг сайн хийж байх.

Зөвлөмж:

- Магистрын хөтөлбөрийн үндэсний стандарт боловсруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулж, сайжруулсан цогц баримт бичгийг боловсруулан мөрдөж байна.
- Хичээлийн хөтөлбөр нь үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн баталгаажуулж, сайжруулсан цогц баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Зөвлөмж:

- Бизнесийн харилцаа, технологи нэн хурдацтай өөрчлөгдөж байгаа өнөө үед хөтөлбөрийн агуулгыг бизнесийн олон талт харилцаа, дижитал технологийн дэвшилд нийцүүлэн байнга шинэчлэн сайжруулж байх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Магистрийн хөтөлбөрийг БСШУС-ын А/370 тоот тушаалын дагуу цогц хэлбэрээр боловсруулан Хөтөлбөрийн хороогоороо хэлэлцэн баталж, хэрэгжүүлж байна. Энэ нь тус сургуулийн эрхэм зорилго, зорилт, стратеги төлөвлөгөөтэй, хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнтэй нийцэж байна.
- Хөтөлбөрийн сургахуйн үр дүн (PLO) болон хичээл тус бүрийн сургахуйн үр дүнгийн (PLO) хоорондын уялдааг матрицаар тодорхойлон харуулсан байна.
- Хичээл болон багшийг сонгон суралцах бүх нөхцөлийг хангаж, хичээлийн жилийн тодорхой хугацаанд, дэс дараалалтайгаар хэрэгжүүлэх журмуудаар зохицуулсан байна.
- Хичээл бүрийн онол, практикийн зохистой харьцааг хангасан, Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан хичээлийн хөтөлбөртэй, дадлагын удирдамжтай (Энэ нь суралцагч ашиглах боломжтой гарын авлагаар тараагддаг.) юм байна.
- Үйлдвэрлэл, практикийн сургалтыг нэг хичээлийг 2-оос доошгүй багш хамтран явуулж байна.
- Бүтээгдэхүүний өртөг тооцолт, Санхүүгийн тайлагнал ба толилуулга гэсэн хоёр хичээлийг Online системд шилжүүлэн зааж байна. Цаашид энэ ажлыг эрчимжүүлэхээр комисс томилон, удирдамжаа боловсруулан эхэлж байна.
- Хичээл хоорондын залгамж холбоог хичээлийн хөтөлбөрийн болон хичээл тус бүрийн суралцахуйн үр дүнтэй нь холбож хангаж өгчээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Сургалтын үйл ажиллагаанд ашиглах дурэм, журмуудыг сайн боловсруулж ашигладаг.

Хөтөлбөрийн сургахуйн үр дүн (PLO) болон хичээл тус бүрийн сургахуйн үр дүнгийн (PLO) хоорондын уялдааг матрицаар тодорхойлон сургалтад ашиглаж байгаа нь туршлага болж байна.

Анхаарах асуудал:

Хичээлүүдийн сургалтын багц материалууд тогтсон нэг загварт оруулсан журмаар зохицуулагдаагүйгээс (Энэ талаар гаргасан журам одоогоор байхгүй.) бүтэц нь харилцан адилгүй, тухайлбал зарим нь лекц, дадлага, лабораторийн хичээл, даалгавар зэрэг бүх заах сэдвийг бүрэн хамарсан байхад зарим нь бүрэн хамраагүй байна.

Сургалтын болон хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулах, шинэчлэн сайжруулахдаа тухайн мэргэжлийн болон хичээлийн хөгжлийн цаашдын хандлага, практик дээр гарч байгаа өөрчлөлтүүдийг сайн харгалздаг боловч оюутан суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид,

багш нар зэрэг оролцогч талуудын санал асуулгыг авч, харгалзан үзээгүй байна. Энэ нь МУИС-ийн хэмжээнд оролцогч тус бүрээс сэтгэл ханамжийн нэг загвар бүхий судалгаа авдагтай холбоотой, энэ талын санал асуулга нь орхигддогт оршиж байна.

Зөвлөмж:

- Багц материал нь тухайн хичээлээр багшийн заах болон оюутны мэдвэл зохих, хийж гүйцэтгэх бүх сэдвийг хамарсан байх төдийгүй тэнд ашиглах үзүүлэн таниулах материал, арга зүй, нэмэлт даалгавар, тэдгээрийг гүйцэтгэхтэй холбоотой удирдамж, заавар зэргийг хамарсан, тасралтгүй боловсронгуй болгох нөхцөлийг хангасан байвал зохистой юм. Өөрөөр хэлбэл тухайн хичээлийг заадаг багш нар нь заах бололцоогүй тохиолдолд мэргэжлийн өөр хичээл заадаг багш нь багц материалыг авч ороод хичээл заах хангалттай материал байх ёстой. Иймд энэ талаар журам боловсруулж мөрдөж ажиллах нь зүйтэй
- Онлайн сургалтыг эрчимжүүлж, бүх хичээлийг энэ системд шилжүүлэх ажлыг тодорхой дэс дараалалтай бэлтгэж ашиглах хэрэгтэй байна.
- Сургалтын болон хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулах, шинэчлэн сайжруулахдаа оюутан суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид зэрэг оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаатай хамт санал асуулгыг авч, сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөр боловсруулахдаа харгалзан үздэг болох нь зүйтэй байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүй боловсруулж ашиглах нэгдсэн арга зүйтэй. Мөн хичээл тус бүрд хичээлийн хөтөлбөрөөрөө ашиглах арга зүйг тогтоож өгсөн байна.
- Сургалтын арга зүйг зохицуулах дүрэм журмуудтай. Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал. Магистрт зааж байгаа хичээл тус бүрээр заах арга зүйг тодорхойлж, түүнийг хичээлийн хэлбэр, суралцахуйн үр дүнтэй холбож өгсөн нь мэдлэг бүтээлгэж, цаашид оюутан өөрөө хөгжих нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.
- Мэдээлэл, харилцаа, холбооны SiSi системийг бүрэн нэвтрүүлж, хичээл болон багшийн сонголт, даалгарын гүйцэтгэлийг хянахад ашигладаг. Сургалтын тоног төхөөрөмж хангалттай.
- Сургалтын үйл ажиллагааны үр дүнд судалгаа хийж, дүгнэлт гарган ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрт зааж байгаа хичээл тус бүрээр заах арга зүйг тодорхойлж, түүнийг хичээлийн хэлбэр, суралцахуйн үр дүнтэй холбож өгсөн нь давуу тал юм.

Зөвлөмж:

- Цаашид сургалтын арга зүйгээ улам сайжруулж ашиглах хэрэгтэй. Тухайлбал хичээл бүрээр, ялангуяа дадлага, лабораторийн хичээлийг явуулах удирдамжуудыг бүрэн боловсруулах, Кейс сургалтын материалуудыг баяжуулан хувилбартай болгох,

хичээл тус бүрээр хэрэглэж байгаа тогтсон арга зүй зохицож байгаа эсэхийг эргэж хянан сайжруулах гэх мэт ажлуудыг жил бүр л хийж байх нь чухал байна.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тогтоож, үнэлдэг арга зүйтэй.
- Магистрт заадаг хичээл тус бүрээр үнэлгээний хэлбэр, үнэлгээ хийх давтамж, үнэлгээний шалгуурыг тогтоож, хичээл тус бүрийн үр дүнтэй холбож өгсөн байна. Энэ нь суралцагчдыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн.
- МУИС-ийн хэмжээнд суралцагчийн үнэлгээг нэгдсэн журмаар тогтоож мөрддөг. Энэ журмыг оюутан суралцагчдын гарын авлагаар нийтэд хүргэдэг. Энэ нь ил тод, шудрага, ижил тэгш байх зарчмыг хангаж байна.
- Сурлагын амжилт, ахицын талаар статистик судалгаа хийж хэвшсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрт заадаг хичээл тус бүрээр үнэлгээний хэлбэр, үнэлгээ хийх давтамж, үнэлгээний шалгуурыг тогтоож, хичээл тус бүрийн үр дүнтэй холбож өгсөн нь туршлага болж байна.

Анхаарах асуудал:

- Нягтлан бодох бүртгэлийн магистрт суралцаж байгаа зарим оюутан нь маркетинг, менежментээр бакалаврын зэрэгтэй төгсөөд элссэн байна. Нягтлан бодох бүртгэлээс бусад бизнесийн удирдлагаар төгссөн тэдгээр оюутнуудын уг мэргэжлийн ангийн суурь шаардлага хангаж байгаа эсэхийг сайн нягтлах хэрэгтэй байна.

Зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлээс бусад бизнесийн удирдлагаар бакалаврын зэрэгтэй төгсөөд энэ ангид элссэн магистрантуудын бакалаврт суралцсан дүнг Дүйцүүлэн тооцох журмынхаа дагуу хянаж үзэх хэрэгтэй байна.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байна.
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, программ ашиглаж байна.
- Цахим орчин хүртээмжтэй, бие даан болон багаар ажиллах орчин хангалттай бүрдсэн байна. Тайланд анги, танхимуудын фото зургийг хавсаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, суралцагчдын ажиллах, сурах таатай орчинг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Магистрант оюутнууд бие даан суралцах анги, танхимын бололцоо нөхцөлийг улам сайжруулах.

Зөвлөмж:

- Сургууль, тэнхимийн зүгээс сургалтын илүү таатай орчинг бий болгохын төлөө байнга анхаарч байх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын үйл ажиллагаанд Макс программыг иж бүрнээр ашиглаж байна. Судалгаагаар хөтөлбөрт суралцаж байгаа оюутнууд: “Танхимд сургалтын техник хэрэгсэл ашиглах боломжтой байдаг” гэж хариулсан байна.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж хүртээмжтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шаардлагатай сургалт, судалгааны программ хангамжуудыг ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын судалгааны программ ашиглах чадварыг улам нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Интернетийн хурд гэх мэтчилэн цахим технологийн нөхцөлийг улам сайжруулах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэргэжлийн 13 хичээлийн үндсэн болон нэмэлт сурах бичгийн хангамж, хүрэлцээ харилцан адилгүй байна. Тэнхимийн номын фондыг баяжуулах, багш нарын хувийн ном, материалыг сургалт, судалгааны ажилд ашиглаж байна.
- 2014 – 2018 онд Нягтлан бодох бүртгэлийн чиглэлийн 57 нэр төрлийн 572 ном авсны 53,5 хувийг Бизнесийн сургуулийн санхүүжилтээр, 46,5 хувийг МУИС-ийн санхүүжилтээр авсан байна. Тайланд сургуулийн төсөвтэй уялдуулан мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлт хийдэг талаар тодорхой дурьдаагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Орчин үеийн, иж бүрэн тоноглогдсон, шинэ номын сантай.

Анхаарах асуудал:

- Сургуулийн төсөвтэй уялдуулан мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийг хийж байх.

Зөвлөмж:

- Магистрын түвшний сургалтын ном, сурах бичиг, гарын авлагыг нэмэгдүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж, хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хөтөлбөрийн хороод боловсруулдаг, хэлэлцдэг, хянан сайжруулдаг тогтолцоог бий болгон хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хороонд багш нараас гадна ажил олгогчдын төлөөлөл ордог.
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудыг (Эрдмийн зөвлөлийн ажиллах журам, Хөтөлбөрийн хорооны журам, Сургалтын журам, Хавсарга хөтөлбөрийн журам, Хөтөлбөр сонгох журам, Магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын ажлын багц цаг тооцоход баримтлах журам) боловсруулан хэрэгжүүлж байна.
- МУИС-ийн болон БС-ийн стратеги төлөвлөгөөнд суурилан НББ-ийн тэнхимийн стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Стратеги төлөвлөгөөний үндсэн чиглэлүүдээ жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган, гүйцэтгэлийг тайлагнаж байна.
- Магистрант оюутны санал хүсэлтийг авахдаа оюутны санал асуулга, саналын хайрцаг аялуулах, зөвлөх багшаар дамжуулан санал авах зэрэг хэлбэрүүдийг ашиглаж байна. Магистрант оюутнуудын санал хүсэлтийн судалгааг 2013-2018 оны хичээлийн жилүүдээр гаргажээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл /Туршлага:

• Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудыг боловсруулан мөрдөж байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмолжуулах.

Зөвлөмж:

- Сургалтын чанарыг сайжруулахад тэнхим, багш, суралцагчдын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Гадаад, дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- МУИС дэлхийн 36 улсын 255 сургууль, байгууллагатай 310 гэрээ байгуулан ажиллаж байгаагаас БС өнгөрсөн жилүүдэд 21 сургууль, байгууллагатай гэрээ багуулан ажиллаж байна. НББ-ийн тэнхмийн хувьд Канадын Сургалтын академи, ОХУ-ын Эрхүү хотын БГУиП-тай хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн өөрийн орны мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.
- Бакалаврын оюутнуудын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан судалгааг гаргасан байна. Магистрант оюутнуудын хувьд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан судалгаа байхгүй байна.
- Хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр дотоодын болон олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд Сангийн яам болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран оролцож байна.
- Багш нарын хувьд олон төрөл, хэлбэрээр нийгэмд, мэргэжлийн хүрээнийхэнд үйлчилгээ үзүүлж байна. Эдгээрийг тайланд тодорхой дэлгэрэнгүй тусгажээ. Харин суралцагчдын зүгээс нийгэмд үзүүлсэн үйлчилгээг дурьдаагүй байна.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал (Тайланд дурдаагүй)
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал (Тайланд дурдаагүй)

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар олон төрөл, хэлбэрээр нийгэмд, мэргэжлийн хүрээнийхэнд үйлчилгээ үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөөг тодорхой болгох.

Зөвлөмж:

- Гадаад хамтын ажиллагааны үр, өгөөжийг нэмэгдүүлэх.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийт орлогын 88,6 хувь нь сургалтын төлбөрийн орлого, 3,4 хувь нь төсвийн санхүүжилт, 8 хувь нь үйл ажиллагааны бус орлого байна. Хөтөлбөрийн хувьд төсөв, санхүүгийн бие даасан байдлыг ханган ажиллах бололцоотой.
- Нэг оюутанд ноогдох өртөг зардлын тооцоог цалингийн зардал, бараа үйлчилгээний зардал, сургалтын үйлчилгээний зардал, эрдэм шинжилгээний зардал, тогтмол зардал, хөрөнгийн зардал гэсэн ангиллаар гаргасан байна.

- Сургалтын шууд зардалд төлбөрийн 70 гаруй хувийг, шууд бус зардалд 20 гаруй хувийг зарцуулж байгаа нь сургалтын төлбөрийн орлого нь зардлаа санхүүжүүлэх хэмжээнд байна.
- Хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэхэд багшийг хөгжүүлэх, дэмжих явдал чухал гэж үзэж багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих, доктор багш нарт жил бүр тодорхой хэмжээний санхүүжилтийг олгож байна.
- Хувийн хэвшлийн дэмжлэг багагүй байна. Тухайлбал, Хаан даатгал, Таван богд, Делойт Онч, Хаан банк, Эрдэнэт үйлдвэр зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд санхүүгийн дэмжлэг үзүүлж, түүнийг нь сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Үйл ажиллагааны бус орлогын дийлэнх хувь нь хадгаламжийн хүүний орлого байна. Аж ахуйн нэгж байгууллагаас орох орлого нэмэгдэж, эрдэм шинжилгээ, инновацийн орлого буурсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийг хөгжүүлэх, дэмжих явдалд анхаарч багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжиж байна. Доктор багш нарт жил бүр тодорхой хэмжээний санхүүжилтийг олгож байна.

Анхаарах асуудал:

- Магистрын хөтөлбөрийн санхүүгийн байдлыг тодорхойлж гаргах.
- Магистрант оюутнуудыг тэтгэлэгт хамруулах.

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээ, инновацийн орлогыг нэмэгдүүлэх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- МУИС-ийн стратеги зорилт, өмнөх жилийн элсэлтийн дундаж тоо, Сангийн яамнаас гаргадаг аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг үндэслэн элсүүлэх квотоо тодорхойлж байна.
- Тэнхимийн цахим хаяг, фэйсбүүк хуудас, тэнхимийн танилцуулга, сурталчилгааны самбар, хүндэтгэлийн самбар, түүхэн замналын ном, баримтат кино, хөтөлбөрийн дагнасан сурталчилгаа зэрэг хэлбэрээр хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийг хийж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургууль, хөтөлбөрийн нэр хүнд сайн, нийтэд танигдсан.

Анхаарах асуудал:

- Судалгааны магиструуд цөөн байгаад анхаарах.

Зөвлөмж:

- Зорилтот бүлэг рүү хандсан маркетингийн идэвхжүүлэлтийг сайн хийх.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- МУИС-ийн сургалт, удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хөнгөвчлөх, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох зорилго бүхий СиСи мэдээллийн системийг 2001 оноос хөгжүүлж ирсэн байна. Уг системээр суралцагчийн элсэхээс төгсөх хүртэлх бүх үйл ажиллагаа хийгдэж байна. СиСи системээс гадна Бүртгэлийн нэгдсэн систем, Төслийн бүртгэл, менежментийн систем, Номын сангийн нээлттэй эхийн Коха систем, Эрдэм шинжилгээний удирдлагын систем зэргийг ашиглаж байна.
- Олон нийтийг хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар өмнө дурьдсан мэдээллийн сувгуудыг ашиглан үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр хангаж байна. МУИС-ийн болон Бизнесийн сургуулийн вебсайтууд тогтмол ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын мэдээллийн системүүдийг сайн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдаас гадна олон нийтэд ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээлэл түгээх талаар анхаарах.

Зөвлөмж:

- Нээлттэй, ил тод байдал хэрхэн хангагдаж байгаа талаар оролцогч, сонирхогч талуудаас судалгаа авдаг байх.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Магистрант элсүүлэх журмыг жил бүр шинэчлэн мөрддөг. Элсэлтийн журам нь хөтөлбөрийн онцлогийг тусган, тасралтгүй сайжирч ирсэн. Жил бүр элсэлтийн журамд хөтөлбөрийн онцлогийг тусгасан шалгуурыг тогтоож мөрддөг.
- Сүүлийн 3 жилд нягтлан бодох бүртгэлийн магистерт 72-85 элсэгч бүртгүүлсэнээс 47 хувь нь элсэлтийн шалгалтад тэнцэж элссэн байна. Тэдний шалгалтын дундаж оноо 69.8 байна. Жил бүрийн дундаж оноог аваад үзвэл 5.8-10 оноогоор өссөн байна. Гэвч жил бүр элсэхээр хүсэгчдийн тоо буурсан байна.
- Шинээр элсэж байгаа оюутнуудыг чиглүүлэх сургалт явуулж, өдөрлөг зохион байгуулдаг. Гарын авлагаар хангаж ажилладаг.

- Нягтлан бодох бүртгэлийн магистрийн сургалтыг 2014-2015 оны хичээлийн жилд 1, 2016-2017 оны хичээлийн жилд 1 гадаад оюутан тус тус элсэн суралцсан байна. Бусад онуудад гадаад оюутан элсэн суралцаагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийн журамд мэргэжлийн онцлогийг сайн тусгасан.

Анхаарах асуудал:

- Дэлхийн тэргүүлэх сургууль болох зорилт тавьж ажиллаж байгаа зорилгоо хангахад Бизнесийн сургууль, тэнхим, ажиллаж байгаа багш нар анхаарч, энэ зорилгоо хангахын тулд бүх мэдлэг, ур чадвараа дайчилж ажиллах хэрэгтэй байна.
- Дээрх зорилготой уялдуулан яаж судалгааны сайн мэргэжилтэн бэлтгэх вэ? гэдэгт бүх сурталчилгаагаа чиглүүлж, судалгаатай ажиллах нь зүйтэй байна.

Зөвлөмж:

- Сайн мэргэжилтэн, эрдэмтэн болж чадах оюутнуудыг сонгож, магистрантурт элсүүлэх ажлыг зохион байгуулахын тулд сурталчилгааг сайн хийх хэрэгтэй.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Магистрыг мэргэжлийн, хөрөнгийн үнэлгээний гэсэн 2 чиглэлээр, дотор нь мэргэжлийн, судалгааны гэсэн 2 сонголттойгоор сургалт явуулдаг. Энэ талаар чиглүүлэх сургалт, өдөрлөг зохион байгуулдаг.
- Зөвлөн туслах үйлчилгээний каледарчилсан төлөвлөгөөтэй. Төлөвлөгөө нь хугацаагаар тодорхойлсон графиктай. Гарах үр дүнг журамдаа тодорхойлсон байна.
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний ажилтнууд ажиллаж байна. Тэдэнд шаардлагатай дүрэм, журам хангалттай. Оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг нэгтгэн чанарын үнэлгээ, сайжруулалт хийдэг.
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал. Бизнесийн харилцаа ба менежерийн ур чадвар, Манлайлал гэсэн 2 хичээлээр бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог.
- Суралцагчдын судалгаа шинжилгээний ажилд багш нар сайн тусалж оролцдог. Энэ нь магистрантын удирдагч багшийг томилж ажиллуулах, эрдэмтэн багш нараар зөвлөгөө өгүүлэх, оюутнуудын багш нартайгаа хамтарч илтгэл тавьж, сургуулийнхаа эрдэм шинжилгээний бүтээлд хэвлүүлэх, бусад энэ чиглэлийн ажлуудаар тодорхой харагдаж байна. Сүүлийн 2 жилд сургуулийн эрдэм шинжилгээний бүтээлд багш нартайгаа хамтарсан 5 илтгэл хэвлэгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар оюутнуудтайгаа хамтарч эрдэм шинжилгээний илтгэл бэлтгэдэг нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- Магиструудад тэтгэлэг хөнгөлөлт олгох хөтөлбөрүүдтэй боловч одоогоор тэдэнд олгосон тэтгэлэг алга байна.
- Магиструудаас сэтгэл ханамжийн болон санал асуулгын судалгааг жил бүр авч үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглаж байх нь чухал байна. Сэтгэл ханамжийн судалгааг 2017, 2018 онуудад л авсан байна.
- Оюутанд зөвлөн туслах 16 үйлчилгээ байдаг юм байна. Эдгээр үйлчилгээ нь нэгдсэн удирдлагатай.

Зөвлөмж:

- Магиструудад тэтгэлэг хөнгөлөлт олгох хөтөлбөрүүдийг сайн сурталчилж, энэ оны сүүлийн хагасаас олгож эхлэх нь зүйтэй.
- Магистрантуудад үзүүлэх үйлчилгээг тэнхим, түүнийг хариуцсан багш, үйлчилгээний алба сайн сурталчилж, хамруулах арга хэмжээ авч ажиллах нь зохистой байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагааны оролцоо, амжилтыг хөхүүлэн дэмжиж хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Магиструудыг олон нийтийн ажил болон дугуйлан клубүүдэд хамруулах журам нь сургуулийн эрхэм зорилгод нийцсэн, сайн боловсрогдсон. Жил бүр тодорхой хэмжээний хангалттай төсвийг сургуулиас нь баталж өгдөг юм байна.
- Магистрантуудыг туслахаар ажиллуулах журмыг боловсруулан ажиллаж байна. Одоогоор 1 оюутан туслахаар ажиллаж байна.
- Магистрантуудад тэтгэлэг, урамшуулал олгох журмуудыг боловсруулан ажиллаж байна.
- Магистрантуудын оролцох боломжтой 9 төрлийн улсын болоод сургуулийн уралдаан тэмцээн байдаг боловч түүнд магистрантууд оролцдоггүй юм байна. Энэ нь магиструуд бүгд ажлын байртай байдагтай холбоотой юм байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магиструудад олон нийтийн ажилд оролцох дүрэм, журмууд хангалттай, оролцох бололцоо ч их байна.

Анхаарах асуудал:

- Магиструудыг олон нийтийн ажил болон дугуйлан клубүүдэд хамруулах ажилд оюутнууд хамрагдаагүй байна. Энэ нь нэг талаар магиструудын ихэнх нь ажлын байртай байдагтай холбоотой боловч тэнхим, сургуулийн зүгээс энэ ажлыг зохион байгуулаагүйтэй холбоотой байна.
- Магиструудад тэтгэлэг хөнгөлөлт, урамшуулал олгох хөтөлбөрүүдтэй боловч одоогоор тэдэнд олгосон урамшуулал, тэтгэлэг алга байна.

- Магиструудаас сэтгэл ханамжийн болон санал асуулгын судалгааг жил бүр авч үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглахгүй байна. Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэггүй, 2017 онд л 1 удаа авсан байна.

Зөвлөмж:

- Магиструудыг олон нийтийн ажил болон дугуйлан клубүүдэд хамруулах ажлыг дэмжиж зохион байгуулах нь олон сайн талуудтай. Магистрантууд өөрсдөө ажлын байртай нөхцөлд дугуйлан, клубд хамруулах бололцоо байхгүй байж болно. Ийм нөхцөлд олон нийтийн ажилд заавал оролцуулах нь тэдэнд өөрсдөд нь ч, бакалаврын зэргээр суралцаж байгаа оюутнуудад ч ач холбогдолтой. Тухайлбал юуны түрүүнд бакалаврын оюутнуудад нийгмийн оролцоо, идэвхийг нь өрнүүлэх, практик дээр ажиллаж байгаа мэргэжилтнүүдээс суралцах, дадлагажих, хамтарч ажиллах, цаашлаад дадлага хийх боломжоо бүрдүүлэх маш сайн талтай. Иймд энэ ажлыг тэнхим, магистр хариуцсан багш нар анхааралдаа авч хийх ёстой.
- Магиструудад тэтгэлэг хөнгөлөлт олгох хөтөлбөрөө сайн сурталчилж, ирэх хичээлийн хагас жилээс эхлэн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- Урамшуулал олгох асуудал бол сургуулийн асуудал. Ийм учраас тэнхим, магистр хариуцсан багш нь энэ асуудлыг судлан үзэж, магиструудаа идэвхжүүлэх зорилгоор ирэх хичээлийн хагас жилээс эхлэн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- Магиструудаас сэтгэл ханамжийн болон санал асуулгын судалгааг жил бүр авч үр дүнг нь харьцуулан дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа ашиглаж байх нь чухал байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Магистрантуудын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, судалсан хичээлийг дүйцүүлэн тооцох журмуудыг боловсруулан мөрдөж байна.
- Багц цагийг дүйцүүлэн тооцох журмынхаа дагуу жилийн чөлөөнөөс ирсэн болон шилжин суралцаж байгаа оюутнуудын тооцоог хийж ажиллаж байна. Шилжилт хөдөлгөөний журмынхаа дагуу магистр хариуцсан багш өргөдлийг нь хүлээн авч, тэнхим, сургуулийнхаа захиргаанд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичиг нь салбарын яамны болон МУИС-ийн дүрэм, журамд нийцсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт**
- Хүний нөөцийн бодлоготой холбоотой 17 дүрэм, журам үйлчилдэг. Багшийн сонгон шалгаруулалтыг хийхдээ тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн дүгнэлт, саналыг үндэслэдэг.
- 2013-2018 онд багшийн сонгон шалгаруулалт, хүний нөөцийн хөгжлийг дэмжих, чадваржуулах талаар холбогдох 4-5 журмыг шинэчилж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.
- **Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин**
- Хөтөлбөрийн доктор багш нарын хувь 2013-2018 онд 35,3-48,3 хувь болсон.
- **Багш суралцагчдын тооны зохистой харьцаа**
- 1 доктор багшид ноогдох магистр оюутны тоо дунджаар 4-5 байна.
- **Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал**
- 2015-2018 онд 2 удаа албан тушаалын зэрэглэлд шалгаруулах үнэлгээний хороо ажиллаж, 2018-2021 он хүртэл дэд профессор, профессорын зэрэглэлд ажиллах багшийг шалгаруулсан байна. Ахлах багш, багшийн орон тоон дээр хэн ажилладаг, хэрхэн шалгаруулдаг талаар тодруулга асуулт хариулт авсан.
- **Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал**
- 2013-2018 онд багш нарын ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, баталгаажуулах чиглэлээр “МУИС-ийн судалгааны журам” шинээр боловсруулж, 3 журмыг шинэчилж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.
- “А” цагт илүү цагийн хөлс тооцдог. Харин Б ба В цагт илүү цаг тооцдоггүй байна.
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд үндэслэн төрийн одон, ЗГ, ТББ-ийн болон МУИС-ийн шилдэг багшийн шагнал олгодог, мөн 2018 оны төсөвт урамшуулалт цалингийн хувийг тусгаж, эхний хагаст 30 хувийн урамшуулал олгосон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн төв байгуулж (2016), мэргэжил ур чадварыг тогтмол сайжруулах хөтөлбөр боловсруулж байгаа юм байна. Хүний нөөцийн цогц бодлогын хүрээнд сонгон шалгаруулалт, хөгжүүлэлтийн хүрээнд түлхүү анхаарч нилээд ажил зохион байгуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хэрхэн шинжилгээ, дүгнэлт өгдөг талаар тайланд дурьдаагүй байсан.
- Урамшууллын хүртээмжийн талаар судалгаа, мэдээлэл байхгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн бодлогын хүрээнд сонгон шалгаруулалт, хөгжүүлэлтийн зэрэгцээ түүний төлөвлөлт, хэрэгжилтэд цогцоор анхаарч ажиллах хэрэгтэй байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал**
- Багш суралцах хэрэгцээгээ өөрөө тодорхойлдог, үүнд үндэслэн тэнхим багшийхаа мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх ажлаа төлөвлөж, тайлагнадаг процедуртай байна.
- **Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт**
- Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллаж байна.
- Багш хөгжлийн төвийн хийсэн ажил нь судалгаа авч, сургалт, заах арга зүй, мэргэжил хувь хүнийг хөгжлийг дэмжих чиглэлээр сургалтууд зохион байгуулсан.
- **Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь гадаад, дотоодод дээшлүүлж чадавхжуулдаг байдал**
 - Багш нарыг гадаад хэлний болон мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах, судалгааны ажил гүйцэтгэх, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, илтгэл хэлэлцүүлэх, олон улсад хянан магадлагаа хийгддэг болон импакт фактор бүхий сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэх зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна.
 - Энэ хугацаанд тус хөтөлбөрийн 20 гаруй багш нар ОХУ, БНСУ, АНУ, БНХАУ зэрэг улсуудын 6 их сургуульд урт, богино хугацааны сургалт, эрдэм шинжилгээний бага хурлуудад оролцсон байна.
 - Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хугацаанд МУ-ын мэргэшсэн нягтлан бодогчийн цолтой багш 83,3 - 92,9 хувь, мэргэшсэн үнэлгээчин багш 45,8-50 хувь нь, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч цолтой багш 16,7-42,9 хувьтай болж мэргэжлийн ур чадвар нь өссөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлбөрийн 2 хувийг багшийн судалгаа, хөгжлийн зардалд зарцуулах санхүүжилтийг тэнхимд олгодог.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн цогц баримт бичиг байхгүй байна.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг иж бүрнээр нь боловсруулж, түүний хэрэгжилтэд үнэлэлт өгдөг, сайжруулалт хийдэг арга зүйтэй болох.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патент, ашигтай загварын тоо**
- НББ-ийн дадлагын сургалтын On-line програм боловсруулж, зохиогчийн эрх авсан.
- **Захиалгат төсөл, судалгаа, гэрээт ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал:**
- ЭШ-ний үр дүнгээр сургалтын агуулгад өөрчлөлт оруулж, хичээл заах уламжлалт арга зүйн хэлбэрээс кейс ажиллах, судалгааны хэлэлцүүлэг хийх зэрэг шинэлэг хэлбэрт шилжиж байгаа юм байна.
- **Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал**
- ЭШ-ий ажлын үр дүнгээ олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх эхлэл тавигдсан.
- **Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж байгаа төсөв, дэмжиж буй байдал**
- Их сургууль судалгааны их сургууль байх шаардлагынхаа дагуу МУИС багш судлаачдаа дэмжих, академик эрх чөлөөг хангах чиглэлээр хэд хэдэн чухал ач холбогдолтой ажил хийж байгаа юм байна. Профессор, дэд профессор багш нарт, тэнхимд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болсон байна. Сургалтын төлбөрийн 2 хувийг багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулахаар тэнхимд хуваарилдаг нь багш нарын судалгааны ажлыг хийх урам өгсөн, чухал дэмжлэг бөгөөд “Б” цагийн гүйцэтгэл сүүлийн жилүүдэд өсч байгаа юм байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн болон багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байдал бусад их сургуульд туршлага болохуйц үр дүнтэй ажил байна.

Анхаарах асуудал:

- Захиалгат төсөл, судалгаа, гэрээт ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга шинэчлэгдэн хөгжсөн байдлыг илтгэх нотолгоо тайлбар хангалттай бус байсан.

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээ олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх ажлыг нэг багшид ноогдох дүнг өсгөхөд анхаарч ажиллах,
- Дотоодын мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөх сэтгүүлийн жагсаалтыг тодорхой хугацаанд баталгаажуулан гаргах, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгоход санал зөвлөмж боловсруулах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Өөрийн үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийдэг байдал**
- Багш бүр хичээлийн жилээр тайлангаа бэлтгэж, өөрийгөө үнэлдэг.
- **Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх/**
 - Багшийн хөндлөнгийн үнэлгээний хувьд аттестатчлалаас гадна суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа авдаг байна.
 - 3-5 жил тутамд холбогдох журмын дагуу аттестатчлалд ордог. 2015-2016 онд нэгдсэн үнэлгээг хийсэн байна.
 - Бизнесийн сургуулийн магистрант докторант оюутнуудаас нийт багш нарын сургалт, заах арга зүйн талаар сэтгэл ханамжийн судалгааны дүнг тайланд тусгасан байна.
 - Сүүлийн 4 жилд докторын зэрэгтэй багш нарын хөндлөнгийн үнэлгээний дундаж 5,7 хувиар өссөн.
- **Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа**
- НББ–ийн хөтөлбөрийн багш нарын сургалт, заах арга зүйг сайжруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд судалгаа хийж, зөвлөгөө, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий Сургалт заах арга зүйн зөвлөл ажиллуулдаг.
- **Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал**
- Сургалт заах арга зүйн зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын үйл ажиллагаанд чанарын хяналтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, үр дүнг тэнхимийн хурлаар хэлэлцүүлсэн байна.
- **Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал**
- Энэ талаар тайланд тусгаагүй боловч нотолгоо мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд зарим багш нартай ярилцлага хийж, тодруулга хийсэн. Багш нарын заавал хөтлөх баримт бичгийн нэг нь багшийн журнал байна. Үүнийг гараар болон Си-Си програмын тусламжтай хөтөлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сургууль, хөтөлбөрийн удирдлагын зүгээс хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн байдал, багш нарын хөгжлийн чиглэлээр ахиц дэвшил, хөгжилд хэрхэн шинжилгээ, дүгнэлт өгдөг, эргэх холбоо бүхий арга бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллах.
- Багшийн үйл ажиллагааны баримт бичгүүдийн жагсаалт, тавигдах шаардлага, бүрдүүлэлт, хөтлөлт, гүйцэтгэлийн чанарын хяналтын чиглэлээр хийдэг ажлуудын талаар тайланд дурьдаагүй байсан.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг иж бүрнээр нь боловсруулж, түүний хэрэгжилтэнд шинжилгээ хийж, үнэлэлт өгдөг, сайжруулалт хийдэг арга зүйтэй байх.
- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил бүр өөрийн болон хөндлөнгийн

үнэлгээг удирдлага, төгсөгч, ажил олгогчийн зүгээс тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байх нь зүйтэй.

- Багшийн үйл ажиллагааны баримт бичгүүдийн хөтлөлт, гүйцэтгэлийн чанарт хөтөлбөрийн удирдлагын зүгээс хэрхэн хяналт тавьдаг талаар нотолгоог бүрдүүлэх нь зүйтэй.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн**
 - Хөтөлбөрийн ерөнхий хороо, Сургалтын нэгдсэн алба, сургалтын албад хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг ажлыг гүйцэтгэдэг.
 - МУИС-ийн академик менежментийг сайжруулах төслийн судалгааны дүнд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын албыг 2017 оны 10 сараас байгуулсан.
 - Энэ алба нь МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны чанарын тогтолцооны схемийг боловсруулсан. Мөн хөтөлбөрүүдийг шинэчилсэн загварт оруулах, архивлах, сан үүсгэх ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.
- **Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ**
 - Сургалтын чанарыг сайжруулах бодлогын хүрээнд сургах, сурахуйн тэргүүлэх чиглэлийн дагуу олон шатлал бүхий зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, холбогдох сургалтын журмуудыг шинэчлэх ажил хийгдэж байна. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтсон дүрэм, журам боловсруулж, түүний дагуу чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг тасралтгүй хийхээр төлөвлөж байна
- **Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо**
 - Хөтөлбөрийн үнэлгээний ажлын хэсэгт захиргааны албаас гадна багш, оюутны төлөөлөл орсон байна. Цаашдаа хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтанд элсэгч, суралцагч, төгсөгч, багш ажилчид, ажил олгогч, өрсөлдөгч, захиргааны албадын оролцоог хангахад анхаарч ажиллахаар төлөвлөж байна.
- **Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг судлан, судалгааны үр дүнг хөтөлбөрийг сайжруулахдаа системтэйгээр ашигладаг байдал**
 - Төгсөгчдөөс ажил эрхлэлтийн судалгааг авдаг.
 - 2014-2015 оны хичээлийн жилд МУИС төгсөгчдийн “мөшгөх” судалгааны дүнд сургалтын бодлогодоо шинэчлэлт хийсэн. Үүний дүнд хөтөлбөрийн хороод байгуулагдан, суралцагчид хөтөлбөрөө, хичээл, багшаа сонгох, хос хавсарга, зэрэгцсэн хөтөлбөрөөр суралцах боломжтой болсон.

- 2014-2015 оны хөтөлбөрийн үр дүнгийн судалгаанд төгсөгчдөөс гадна ажил олгогчдыг хамруулсан. Ажил олгогчид төгсөгчдийн ажлын гүйцэтгэл, ур чадварт сэтгэл хангалуун харин гадаад хэлний мэдлэг, асуудлыг тайлбарлах чадвар зэрэгт сэтгэл хангалуун бус буйг тодорхойлсон байна.
- Судалгааны дүнг үндэслэн ерөнхий суурь хичээлүүдийн агуулгад хувь хүний төлөвшил, хандлага, анхан шатны ур чадварыг дээшлүүлэх агуулгыг нэмж оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг тогтмол давтамжтай хийж, дүн шинжилгээ хийх.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын ажлыг шинэ шаардлагын дагуу иж бүрнээр гүйцэтгэх ажил удаашралтай явагдаж байна. /МУИС-д чанарын баталгаажуулалтын алба байгуулагдаад жил гаруй болсон байна./

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бодлого, журмыг богино хугацаанд боловсруулж ашиглах нь зохистой байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерийн өсөлт, ажлын байраар хангагдах хүртэлх хүлээхэд зарцуулах дундаж хугацааны судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал**
 - 2017-2018 оны судалгаагаар магистрын хөтөлбөр төгсөгчдийн 75,8 хувь нь нягтлан бодогчоор, 21,2 хувь нь өөр мэргэжлээр 3,03 хувь нь ажил эрхлээгүй байна.
 - Ажил эрхлэлтийн түвшин 2016-2017 оны байдлаар 85,4 хувь байна.
 - 2016-2017 оны судалгаагаар төгсөгчдийн 72,0 хувь нь 0-3 сар, 20,7 хувь нь 4-6 сар, 3,7 хувь нь 7-12 сарын дотор, 3,7 хувь нь 1 жилээс дээш хугацаанд ажилд орсон байна.
 - Төгсөгчдийн 73,5 хувь нь тогтвор суурьшилтай ажиллаж байна.
- **Хөтөлбөрт оролцогчдын сэтгэл ханамжийн судалгаа, үр дүн, ахиц**
 - Ахисан түвшний суралцагсдын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр хийхээр төлөвлөсөн байна.
 - Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг суралцагч, багш, төгсөгч, ажил олгогч гэсэн оролцогч талуудаар ангилан хийсэн. Үүнд бакалаврын суралцагсдын судалгааг 2016 онд, төгсөгчдийн судалгааг 2008, 2011, 2017 онд, ажил олгогчийн судалгааг 2008, 2012, 2017 онд, багш нарын судалгааг 2017 онд, ахисан түвшний суралцагчдаас авах сэтгэл ханамжийн судалгааг 2017-2018 оны хичээлийн жилд явуулсан байна. Сэтгэл ханамжийн судалгааны дүн харьцангуй “хангалттай” гэж үнэлэгдсэн байна.
 - Ажил олгогчид төгсөгчдийн мэдлэг чадвар, сургуулийн нэр хүнд, багш нарын чадвар, сургалтын чанарыг өндрөөр үнэлдэг. Харин төгсөгчдийн харилцааны

ур чадвар, ажилд бүтээлчээр хандах хандлагад анхаарч, практик мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна.

- **Дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь**
 - Магистрт суралцагсдын 10 хувь, докторантурт суралцагсдын 32 хувь нь өмнөх шатны хөтөлбөрөөс үргэлжлүүлэн сурч байна. Энэ хувь хэмжээ НББ хөтөлбөрийн багш нарын хувьд 40 гаруй хувьтай байна.
- **Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал**
 - 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн давтан сургалтын төлөвлөгөө боловсруулж байна.
- **Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал**
 - Бизнесийн сургуулийн төгсөгчдийн холбоо ТББ байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2011-2013 онуудад төгсөгчдийн мэдээлэл, харилцаа холбоог сайжруулах, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулсан бөгөөд цаашдаа үйл ажиллагааг нь ерөнхийдөө тогтмолжуулахад анхааран ажиллаж байна.
- **Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа**
 - Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг 2016-2017 онд багш нараас, 2017-2018 онд төгсөх магистрантын дунд явуулсан байна. Багш нараас авсан судалгаанаас 92,3 хувь нь хөтөлбөрийн үр дүнд сэтгэл хангалуун гэж дүгнэсэн. Магистрантуудын 75 хувь нь хөтөлбөрийн үр дүнг хангалттай сайн бөгөөд 76,1 хувь нь хөтөлбөр орчин үеийн шинэ агуулгатай, зах зээлийн эрэлтэд нийцсэн гэж дүгнэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа бүр 75 хувиас дээш эерэг сайн үнэлгээтэй гарсан.

Анхаарах асуудал:

- Энэ тайланд тэмдэглэсэн судалгаануудын хувьд хамрах хүрээ /оролцогчид/, давтамжийн хувьд харилцан адилгүй байна.

Зөвлөмж:

- НББ-ийн чанарын үнэлгээ, судалгаанд оролцогч талуудыг бүрэн хамруулж, тодорхой давтамжтайгаар тасралтгүй хийж, жил бүрийн үр дүнг хөтөлбөрийн сайжруулалт, бодлогын шийдвэрт ашиглах нь чанарын баталгаажуулалтыг гүйцэтгэхэд чухал нөлөөтэй.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- **Олон улсын магадлан итгэмжлэлийн үр дүн**
 - Ахисан түвшний сургалтын хөтөлбөрүүд олон улсын магадлан итгэмжлэлд ороогүй байна.
- **Мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөнийг нотлох баримт бичиг**

- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрөө дотооддоо 2006 ба 2013 онд 2 удаа БМИҮЗ-өөр, олон усад АНУ-ын бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэлийн /ACBSP/ байгууллагаар 2013 онд магадлан итгэмжлүүлсэн.
 - НББ-ийн бакалаврын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн стандарт боловсруулж, батлуулсан. Энэ нь уг хөтөлбөрийн мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөнийг нотлох баримт гэж дүгнэсэнтэй санал нэг байна.
- **Холбогдох мэргэжлийн холбоодоор хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байдал**
- Эдгээр байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ACBSP-ийн албан ёсны түнш оюутны мэдлэг, ур чадварын хөндлөнгийн үнэлгээний Peregrine байгууллагаас олон улсад магадлан итгэмжлэгдсэн болон гишүүн элссэн Монголын 20 орчим их дээд сургуулиудаас оюутны мэдлэг, ур чадварын хөндлөнгийн үнэлгээгээр тэргүүлж, “Үндэсний шилдэг сургууль”-аар шалгарсан туршлагатай.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын болон үр нөлөөний үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үйл явцад мэргэжлийн холбоодын үүрэг сул, эдгээр байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй байна.
- Хөтөлбөрийн чанарын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, чанарын баталгаажуулалт хийх, хөтөлбөрийг удирдлага зохион байгуулалтаар хангах, оролцогч талуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх, сайжруулах зорилгоор чанарын баталгаажуулалтын алба ба хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны ажил үүргийн хуваарьт тодорхой болгох, уялдуулах шаардлага байна.

Зөвлөмж:

- Цаашид НББ-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг гүйцэтгэх, хөтөлбөрийн чанарын болон үр нөлөөний үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үйл явцад суралцагч, багш, ажил олгогч, төгсөгч, хөндлөнгийн оролцогч байгууллага зэрэг оролцогч талуудыг бүрэн хамруулж, тус тусын үүрэг оролцоог нь нарийвчлан тодорхойлж, ажиллахад анхаарч, энэ үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар тасралтгүй хийдэг үйл ажиллагаа болгох, жил бүрийн үнэлгээ, дүгнэлтийн үр дүнг бодлогын шийдвэрт тусгуулах нь хөтөлбөрийн сайжруулалт, хөгжилд чухал гэж үзэж байна.

ДУГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			4.2 хэсэгчлэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ баталгаажуулалт	2			7.1 хэсэгчлэн хангасан
Дүгнэлт		Бүрэн хангасан			

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

- Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын тэргүүлэх сургууль МУИС Дэлхийн тэргүүлэх сургуулийн нэг болох зорилт тавин ажиллаж байгаа нь зүй ёсны асуудал юм. Ийм хэмжээнд хүрэх асуудал тэнд ажиллаж байгаа багш нар болон тэнхим, салбар сургуулиас эхлэх ёстой. Иймд ажиллаж байгаа багш нар нь доктор (Ph)-ээс доошгүй зэрэгтэй, багш бүр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн фактор сэтгүүлд өгуулэл хэвлүүлсэн байх хэрэгтэй байна. Энэ тал дээр анхаарч, тодорхой төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатаг гэж үзэж байна.
- Хөтөлбөрийн хүний нөөцийн бодлогын хүрээнд сонгон шалгаруулалт, хөгжүүлэлтийн зэрэгцээ түүний төлөвлөлт, хэрэгжилтэд цогцоор анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг иж бүрнээр нь боловсруулж, түүний хэрэгжилтэд үнэлэлт өгдөг, сайжруулалт хийдэг арга зүйтэй байх нь чухал юм.
- МУИС-ийн хэмжээнд болон мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд дотоодын мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөх сэтгүүлийн жагсаалтыг тодорхой хугацаанд баталгаажуулан гаргах, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгоход санал зөвлөмж боловсруулж ажиллах хэрэгтэй.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бодлого, журмыг богино хугацаанд боловсруулах хэрэгтэй байна.

6. Цаашид НББ-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг гүйцэтгэх, хөтөлбөрийн чанарын болон үр нөлөөний үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үйл явцад суралцагч, багш, ажил олгогч, төгсөгч, хөндлөнгийн оролцогч байгууллага зэрэг оролцогч талуудыг бүрэн хамруулж, тус тусын үүрэг оролцоог нь нарийвчлан тодорхойлж ажиллахад анхаарч, энэ үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар тасралтгүй хийдэг үйл ажиллагаа болгох, жил бүрийн үнэлгээ, дүгнэлтийн үр дүнг бодлогын шийдвэрт тусгуулах нь хөтөлбөрийн сайжруулалт, хөгжилд чухал гэж үзэж байна.

Ерөнхий дүгнэлт:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг хэлэлцэн баталгаажуулж өгөхийг хүсч, Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд үнэлгээний эцсийн тайланг хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэгЛ.Энх-Амгалан

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....С.Өлзийбат

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....С.Алтанцэцэг

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил/МУИС-д	Заадаг хичээл
1	Л.Наранчимэг	Тэнхмийн эрхлэгч	Доктор, дэд профессор	27	
2	Н.Тунгалаг	Профессор	Доктор, профессор	35	
3	А.Өнөржаргал	Дэд профессор	Доктор, дэд профессор	18	
4	Д.Нямаа	Дэд профессор	Доктор, дэд профессор	25	
5	Б.Оюунцэцэг	Багш	Доктор	13	

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
	Ө.Ариунболд	I	
	Б.Мөнхшүр	II	
	Э.Мөнхтуяа	II	
	Д.Бас-Оргил	II	
	Г.Отгонсүрэн	I	
	М.Уранчимэг	I	
	М.Борням	I	
	Ц.Цолмон	II	
	Д.Гантулга	I	
	Б.Энхцацрал	I	

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
	Д.Нацагдорж	АШУУИС	Санхүүгийн албаны дарга
	С.Энхзаяа	“ДНДХ” ХХК	Гүйцэтгэх захирал
	Т.Сугарсүрэн	“Нийслэл аудит” ХХК	Захирал
	М.Өлзийбат	Санхүүгийн зохицуулах хороо	Газрын дарга
	Н.Мягмаржав	“Од Бүртгэл аудит” ХХК	Гүйцэтгэх захирал
	Н.Мөнхбаясгалан	“МТ” ХХК	Санхүүгийн хэлтсийн дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Б.Отгонбаяр	2017	Австралийн хөрөнгө оруулалттай компани ХУИС	Нягтлан бодогч
2	Т.Энхсайхан	2016	ХУИС	Багш
3	Д.Сарантуяа	1999	“Сити шоп” ХХК	Нягтлан бодогч
4	З.Сумъяа	2006	“Чөлөөт хэвлэл” сан	Санхүүгийн албаны дарга
5	Г.Долгорсүрэн	2018	Ипотекийн корпораци	Нягтлан бодогч
6	Н.Мягмаржав	2000	“Од Бүртгэл аудит” ХХК	Гүйцэтгэх захирал
7	Г.Онон	2017	Шүүхийн ерөнхий зөвлөл	Дотоод аудитор
8	Б.Өлзийзаяа	2016	“Нийслэл аудит” ХХК	Аудитор
9	Х.Минжин	2018	КПМЖ аудит ХХК	Аудитор
10	Л.Цогтбилэг	2018	“МТ” ХХК	Дотоод аудитор

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-45а ш/х-480, Сүхбаатар дүүрэг,
Баян тогтоо 4, Утас/Факс: (976-11) 35-09-94,
E-mail: bs@num.edu.mn, http://bs.num.edu.mn

2019.01.04 № 8/02

танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Нягтлан бодох бүртгэл (E04110101)-ийн магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчдийн дүгнэлтэнд өгөх саналыг үүгээр хүргүүлж байна.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ,
ПРОФЕССОР



Ч.ЭНХБАЯР

**МУИС-БС-ийн НББ-ийн МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙГ (E04110101)
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШИНЖЭЭЧДИЙН ДҮГНЭЛТЭД ӨГӨХ САНАЛ**

МУИС-БС-ийн Нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн бизнесийн удирдлагын магистрын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчдийн дүгнэлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

1. Шинжээчийн өгсөн санал, зөвлөмжийн талаар

Шинжээчийн зүгээс шалгуур тус бүрээр үзүүлэлт нотолгоо, онцлог зүйл/туршлага, анхаарах асуудал, зөвлөмж гэсэн хэсгүүдээр дүгнэлтээ ирүүлжээ. Шинжээчдийн өгсөн санал дүгнэлт, сайжруулах санал зөвлөмжүүдийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж (тэнхим), БС-ийн удирдлага санал нэгтэй хүлээн авч цаашдын бодлого, үйл ажиллагааны зорилт төлөвлөгөөндээ тусган хэрэгжүүлэх болно гэдгийг илэрхийлж байна.

1.1 Шинжээчийн дүгнэлтэнд тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал.

- Суралцагчдыг олон нийтийн ажилд оролцуулах, тэтгэлэг урамшуулалт хамруулах талаар цаашид тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллана.
- Хөтөлбөрийн сайжруулалтын талаар оролцогч талуудтай илүү ойр хамтран ажиллана
- МУИС-д шинээр батлагдаж мөрдөгдөх (2019 оны 2 сараас) “Хөтөлбөр түүний үнэлгээ чанарын баталгаажуулалтын журам”-ыг даган мөрдөх, хөтөлбөрийн чанарын үнэлгээг тогтмолжуулах
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг иж бүрнээр боловсруулж, мөрдөх

1.2 Шинжээчийн өгсөн үнэлгээ дүгнэлт, санал зөвлөмжийн зарим хэсэгт дараах тайлбарыг өгч байна.

- Шалгуур 2-ийн шинжээчийн дүгнэлтэнд “ сургалтын болон хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулах, шинэчлэн сайжруулахдаа тухайн мэргэжлийн болон хичээлийн хөгжлийн цаашидын хандлага, практик дээр гарч байгаа өөрчлөлтүүдийг сайн харгалздаг боловч оюутан суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид, багш нар зэрэг оролцогч талуудын санал асуулгыг авч харгалзан үзээгүй байна” гэж дүгнэжээ. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахдаа МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны журмын дагуу тэнхимийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцэж, тэнхимийн хурлаар дэмжин улмаар бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцэж, МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороогоор шийдвэрлэдэг. Оюутнуудаас болон оролцогч талуудаас санал авсны үндсэн дээр сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах талаар хэлэлцсэн хурлын протокол, үр дүнг тайланд тусгаж, Хөтөлбөрийн удирдлага гэсэн шалгуурт буюу тайлангийн 74-р хуудсанд бичсэнийг анхаарч үзнэ үү

- Шалгуур 2-ийн шинжээчийн дүгнэлтэнд “*Нягтлан бодох бүртгэлийн магистрт суралцаж байгаа зарим оюутан нь маркетинг, менежментээр бакалаврын зэрэгтэй төгсөөд элссэн байна. НББ-ээс бусад бизнесийн удирдлагаар бакалаврын зэрэгтэй төгсөөд энэ ангид элсэн магистрантуудын бакалаврт суралцсан дүнг дүйцүүлэн тооцох журмынхаа дагуу хянаж үзэх хэрэгтэй байна*” гэж дүгнэжээ. МУИС-ын сургалтын журмын 3.7.2-т зааснаар “Магистрын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр бакалаврын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15 хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны бакалаврын түвшний мэргэжлийн суурь хичээлүүдээс бүрдэнэ” гэж заасны дагуу бэлтгэл магистрын сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөрдөж байгаа. Энэ талаар тайлангийн 33-р хуудсанд тусгасан төдийгүй, уулзалтын явцад яригдсан болно.
- Шалгуурт 4-ын шинжээчийн дүгнэлтэнд “*Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал*” тайланд тусгаагүй гэжээ. Энэ талаар шалгуур 7-г буюу тайлангийн 159-160 хуудсанд бичсэн байгааг анхаарч үзнэ үү
- Шалгуур 5-ын шинжээчийн дүгнэлтэнд “*магиструудаас сэтгэл ханамжийн болон санал асуулгын судалгааг жил бүр авч үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглаж байх нь чухал. Сэтгэл ханамжийн судалгааг 2017 онд л нэг удаа авсан байна гэж дүгнэсэн*” Бизнесийн сургуулийн хэмжээгээр магистрант оюутнуудын судалгааг 2017 онд авч нэгтгэсэн. Харин тэнхимийн хэмжээнд магистрант оюутнуудаас 2017, 2018 онуудад судалгаа авч (хөтөлбөрийн үр дүнгийн талаар) нэгтгэн үр дүнг тайланд тусгасан төдийгүй, СиСи системээр (тайлангийн 39-44 р хуудсанд) хичээлийн жилийн улирал бүрт оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Магистрант оюутнуудын СиСи системээр өгсөн санал асуулгын дүнг БС-ийн хэмжээгээр болон бусад тэнхимүүдтэй харьцуулсан (тайлангийн 20- р хуудас) дүгнэлт хийж тайланд төдийгүй, хөтөлбөрийн танилцуулганд тусгасан болно.

Захирал

Тэнхимийн эрхлэгч



проф Ч.Энхбаяр

проф Л.Наранчимэг

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж: /Recomendations/